



**Нийгэмд
Мэдлэг
Хэрэглэх
Байдал**

Фридрих Аугуст
фон Хаек

**American Economic Review сэтгүүлийн эхний 100 жилийн
шилдэг 20 нийтлэлийн нэг**

Нийгэмд Мэдлэг Хэрэглэх Байдал

Фрийдрих Аугуст фон Хаек

ННА 65.01
ДАА 330.01
Б-906

The Use of Knowledge in Society
by Friedrich August von Hayek

Copyright © American Economic Association; reproduced with permission of the American Economic Review.

Нийгэмд Мэдлэг Хэрэглэх Байдал/Явдал
Фридрих Аугуст фон Хаек

Монгол орчуулгын анхны хэвлэл: 2022 он
Англи хэлнээс орчуулсан: Намхайнямын Жаргал

Монгол орчуулгын эрхийг © 2022 Намхайнямын Жаргал эзэмшдэг.
Бүх эрхийг хуулиар хамгаалсан болно.

Энэхүү бүтээлийг Улстөрийн Нам, ТББ-аас бусад хувь хүн файл хэлбэрээр татаж авах, олшруулж, бусдад дамжуулах, хэсэгчилж эсвэл бүтнээрээ нь хэвлэх нь цөм чөлөөтэй бөгөөд гагцхүү орчуулагчийн нэрийг түүндээ дурдах ёстой. Улстөрийн Нам, ТББ хэрэглэх бол орчуулагчаас зөвшөөрөл авна.

“Эрх Чөлөөт Хүмүүст Зориулсан Номын-Сан” нэртэй вэбхуудасанд зориулж файлаар хэвлэв. www.libraryforfreereople.mn

Американ Экономик Ривю сэтгүүлийн зөвшөөрлөөр орчуулав.
Хавтасны зураг: Фридрих Аугуст фон Хаекийн гэрэлзураг.

Нийгэмд Мэдлэг Ашиглах Байдал

Фрийдрих Аугуст фон Хаек

Нийгэмд Мэдлэг Ашиглах Байдал

Ф. А. Хаек, “Нийгэмд Мэдлэг Ашиглах Байдал” *American Economic Review* сэтгүүл, XXXV боть, No. 4; 1945 оны 9-р сар, 519–530-р нүүр.

I

Эдийн засгийн эрүүл буюу рационал^[1] дэг журам байгуулахыг оролдохдоо бид ямар асуудал бэрхшээлийг шийдэх гэж хүсдэг вэ? Олны мэддэг тодорхой төсөөллүүдээр бол үүний хариулт тун энгийн. Хэрэв бид бүх зохистой мэдээлэлтэй бол, хэрэв бид илүү гэж үзсэн өгөгдсөн тогтолцооноос эхлэх боломжтой бол, хэрэв бид бэлэн байгаа арга хэрэгслийн талаар бүрэн гүйцэт мэдлэг эзэмшдэгсэн бол энэ асуудалд цэвэр логикийн асуудал л үлдэх болно. Тиймээс л байгаа арга хэрэгслийн хамгийн сайн хэрэглээ нь юу болох тухай асуултын хариулт нь бидний төсөөлөлд үл анзаарагдам байдлаар оршдог. Энэхүү хамгийн өөдрөг асуудл^[2]ын шийдлийг хангах ёстой нөхцлийг математик хэлбэрээр бүрэн гүйцэт боловсруулж гаргах, мөн хамгийн сайн томьёолох боломжтой: хамгийн товчхон илэрхийлбэл аливаа хоёр бараа таваар эсвэл [үйлдвэрлэлийн] арга хэрэгсл^[3]ийн хоорондохь солилцооны хязгаарын хэмжээ^[4] бүх өөр өөр хэрэглээнд ижилхэн байх ёстой ажээ.

Гэвч энэ байдал бол нийгэмд тулгардаг эдийн засгийн асуудал ерөөсөө биш юм. Хэдий нийгмийн эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд чухал алхам байдаг ч энэхүү логик асуудлыг шийдвэрлэхээр хөгжүүлсэн эдийн засгийн тооцоо хараахан үүнд

1 эрүүл ухаанаар үүссэн, цогцлосон

2 *optimum problem*

3 *commodities and factors*

4 *marginal rates of substitution*

хариулт өгөхгүй. Үүний шалтгаан нь эдийн засгийн тооцоо эхлэдэг “өгөгдөл”-ийг бүхэл нийгэмд зориулан дүгнэлт гаргах боломжтой нэг ухаантан хэзээ ч “мэдэж байсан”-гүй, мөн ингэх боломж олгох байдлаар түүнд хэзээ ч өгөх боломжгүй явдал билээ.

Эдийн засгийн рационал/эрүүл дэг журмын өвөрмөц байдал бол нөхцөл байдлын тухай бидний хэрэглэх ёстой болдог мэдлэг хэзээ ч нэг дор цугларсан эсвэл нэгдэж нийлсэн хэлбэртэй байдаггүй харин бүгдийг нь тус тусдаа хувь хүмүүс эзэмшдэг мэддэг, бүрэн гүйцэт зүйлийн байнга шахуу хоорондоо зөрчилтэй мэдлэгийн сарниж тархсан хэсэг байдалтай зөвхөн оршдог гэсэн бодит байдал юм. Тийм учраас нийгмийн эдийн засгийн асуудал “өгөгдсөн” гэдгийг эдгээр “өгөгдөл”-өөр бүрдэж гарсан асуудлыг албадмал байдлаар шийдвэрлэдэг нэг ухаантанд өгөгдсөн гэж ойлгон “өгөгдсөн” нөөц баялагийг байршуулах л асуудал биш ажээ. Энэ нь илүүтэй нийгмийн аливаа гишүүдийн мэдэх нөөц баялагийг энэ хувь хүмүүс л зөвхөн харьцангуй ач холбогдлыг нь мэддэг зорилгын төлөө хамгийн сайнаар хэрэглэх хэрэглээг хэрхэн бататгаж бэхжүүлэх гэсэн асуудал байдаг. Эс бөгөөс товчхоноор хэлбэл энэ бол хэн нэгэн ямар ч хүн бүхэл байдлаар нь мэддэггүй эзэмшдэггүй мэдлэгийг хэрэглэх тухай л асуудал юм.

Энэхүү суурь асуудлын энэ шинжийг ил гаргасан гэхээсээ илүүтэй, эдийн засгийн онолыг сүүлийн үед сайжруулах гэсэн үйлдлээр, ялангуяа математик ихээр хэрэглэх болсон явдлаар бүдэгрүүлсэн гэж би санаа зовж байна. Хэдий энэ нийтлэлд голчлон анхаарал хандуулахыг хүсч буй энэ асуудал эдийн засгийг рационал байдлаар зохион байгуулах явдлын талаархи асуудал байх ч би ингэх явцдаа дахин дахин үүнийг аргагүй тодорхой асуудалтай нягт холбоотой болохыг нь цохон зааж байх болно. Миний зааж хэлэхийг хүссэн олон зүйл үнэндээ сэтгэлгээний олон янзын арга зам санамсаргүйгээр уулзаж нийлдэг тэр л дүгнэлт байх болно. Гэвч эдгээр асуудлыг миний бие одоо харж ойлгож байгаачлан энэ нь тохиолдлын хэрэг биш ажээ. Эдийн засгийн онол болон эдийн засгийн бодлоготой хоёултай нь холбоотой өнөөгийн маргааны олон нь нийгмийн эдийн засгийн асуудал бэрхшээлийн байр

байдлын талаархи алдаатай концепцээс ижилхэн үүсч гарсан гэж надад санагддаг. Байгалийн юмс үзэгдлийг судлах үедээ үүсгэж хөгжүүлсэн бодож сэтгэх зан байдл⁵ынхаа нийгмийн юмс үзэгдэл рүү алдаатай шилжсэнээс энэхүү алдаатай концепц эргээд өөрөө бий болсон ажээ.

II

Энгийнээр хэлбэл бид бэлэн байгаа нөөц баялагаа байршуулах талаархи харилцан холбоотой нийлмэл шийдвэрийг “төлөвлөлт, төлөвлөх” гэсэн үгээр дүрсэлж тайлбарладаг. Эдийн засгийн бүх үйл ажиллагаа энэ утгаар бол төлөвлөлт ажээ; олон хүмүүс хамтран ажилладаг аливаа нийгэмд энэхүү төлөвлөлт хэнбугай нь үүнийг хийдэг байсан ч юуны түрүүнд энэ нь ямар нэг хэмжээгээр тухайн төлөвлөгчид өгөгдөөгүй ч уг төлөвлөгчид ямар нэг байдлаар дамжиж хүрсэн, өөр хэн нэгэн хүний мэддэг эзэмшдэг мэдлэгт үндэслэсэн байх болно. Хүмүүс төлөвлөгөөгөө үндэслэдэг гаргадаг мэдлэг тэр хүмүүсийн хооронд дамждаг янз бүрийн арга зам бол эдийн засгийн үйл явцыг тайлбарлах онолын хувьд хамгийн гол асуудал байдаг бөгөөд хүмүүс дунд анхандаа тарсан байсан мэдлэгийг хэрэглэж ашиглах хамгийн сайн арга зам юу болох талаархи асуудал дор хаяж эдийн засгийн бодлогын гол асуудал бэрхшээлийн нэг эсвэл эдийн засгийн үр өгөөжтэй тогтолцоог зохиомжлох явдал байдаг.

Энэхүү асуудлын хариулт хэн энэ төлөвлөлтийг энд хийх вэ гэдгээс ургаж гардаг өөр нэг асуудалтай холбоотой. Энэ л асуудлын эргэн тойронд “эдийн засгийн төлөвлөлт”-ийн тухай бүх маргаан төвлөрдөг. Энэ бол төлөвлөлтийг хийх эсвэл үгүй эсэх талаархи маргаан биш. Энэ нь төлөвлөлтийг төвлөрсөн байдлаар, эдийн засгийн нийт тогтолцоонд зориулж нэг байгууллага хийх эсвэл олон хувь хүмүүсийн дунд хуваагдсан байдлаар хийх эсэх тухай маргаан билээ. Төлөвлөлт гэдэг нь энэ ойлголтыг орчин үед урвуугаар нь ашигласан тэр онцгой утгаараа зайлшгүй төвлөрсөн

5 *habits of thought*

төлөвлөлт, эдийн засгийн нийт тогтолцоог нэгдсэн төлөвлөгөөгөөр чиглүүлж удирдана гэсэн үг байдаг. Нөгөө талаас өрсөлдөөн гэдэг нь олон тус тусдаа хувь хүмүүс төвлөрсөн байдалгүйгээр төлөвлөлтөө хийнэ гэсэн үг юм. Энэ хоёрын дунд оршдог, олон хүн тэр тухай нь ярьдаг ч цөөхөн нь үүнийг үзээд баярладаг байшин бол зохион байгуулалтад орсон аж үйлдвэр рүү төлөвлөлтийг дамжуулан өгөх^[6], эсвэл өөрөөр хэлбэл монополь ажээ.

Эдгээр тогтолцооны аль нь илүү үр өгөөжтэй байх нь байгаа мэдлэгийг аль тогтолцоонд нь илүү бүрэн хэрэглэх боломжтой байх болно гэж бид хүлээж буй явдлаас голчлон хамаарах магадлалтай. Эргээд энэ хүлээлт ашиглах ёстой ч анхнаасаа олон өөр өөр хувь хүмүүсийн дунд сарниж тархсан байдаг бүх мэдлэгийг ганц төвлөрсөн засаг захиргааны мэдэлд өгөхдөө амжилт олох эсвэл бусдын төлөвлөгөөнд өөрсдийнхөө төлөвлөгөөг нийцүүлэх боломж гарахад тэдэнд хэрэгцээтэй иймэрхүү [сарниж тархсан] нэмэлт мэдлэгийг хувь хүнд дамжуулж өгч чадсан эсэхээс хамаарна.

III

Энэ чухал санааны талаархи байр суурь мэдлэгийн өөр өөр төрлийн хувьд ондоо ондоо байдаг нь нэгэнт илэрхий байдаг; бидний асуултын хариулт тийм учраас мэдлэгийн янз бүрийн төрлийн харьцангуй ач холбогдолоос нилээд хамаарна; эдгээр төрөл бол тодорхой хувь хүний мэдэлд илүүтэй байх боломжтой мэдлэг, мөн тохиромжтой байдлаар сонгож авсан шинжээчдээс бүрддэг засаг захиргааны мэдэлд байна гэж бидний итгэлтэйгээр боддог тэр мэдлэг юм. Хэрэв өнөөдөр бид сүүлд дурдсан мэдлэг илүү сайн байр суурьтай байх болно гэж өргөн олноороо төсөөлдөг бол энэ байдал мэдлэгийн нэг төрөл, дурдаж нэрлэбэл шинжлэх ухааны мэдлэг мэдлэгийн тохирох цор ганц төрөл биш болохыг гэдгийг мартаж хандлагатай олон нийтийн төсөөлөлд нэр хүндтэй байранд байдаг учраас тэр ажээ. Шинжлэх ухааны мэдлэгт анхаарал хандуулсаар байх хүртэл нийцтэйгээр сонгож авсан мэргэжилтний

6 *delegation of planning to organized industries*

байгууллага хамгийн сайн мэдлэгийг удирдаж хэрэглэх хамгийн сайн байр сууринд байдаг гэдгийг хүлээн зөвшөөрч болох юм-гээд энэ байдал мэдээжээр тухайн мэргэжилтнүүдийг сонгон авах/шилж авах явдлын асуудал руу хүндрэлтэй байдлыг шилжүүлдэг. Миний цохон заахыг хүсч буй зүйл бол бүр энэ асуудлыг даруй хялбар шийдэх боломжтой гэж төсөөлж үзэж байсан ч энэ асуудал илүү өргөн хүрээтэй асуудлын зөвхөн багахан хэсэг л байдаг гэсэн санаа билээ.

Өнөөдөр шинжлэх ухааны мэдлэг бол нийт мэдлэгийн нийлбэр биш юм гэж сануулж хэлэх нь бараг гэмт хэрэг болжээ. Гэвч бага зэрэг л эргэцүүлж бодоход л нийтийн-дагадаг ёс журмын мэдлэг⁷ийн хүрээнд шинжлэх ухааны гэж нэрлэх боломжгүй, маш чухал ч зохион байгуулагдаагүй мэдлэгийн бүтэц оршдог гэдэг нь маш тодорхой харагдах болно: энэ бол цаг хугацаа болон газрын тодорхой нөхцөл байдлын тухай мэдлэг юм. Энэ талаасаа бараг л хувь хүн бүр тэрбээр үр өгөөжтэй хэрэглэх боломжтой боловч хэрэв түүнд энэ мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах явдлыг үлдээвэл эсвэл ийм шийдвэрийг түүний идэвхитэй оролцоотойгоор гарвал л ашиглах бололцоотой давтагдашгүй цор ганц мэдээлэл эзэмшдэг мэддэг учраас бусад бүх хүнээс зарим нэг давуу талтай байдаг. Зөвхөн онолын давтлагаа дуусгасны дараагаар аливаа мэргэжлээр ажиллахдаа хэр ихийг сурдаг болох, бид ажил амьдралын хэр их хэсгийг тодорхой ажил хийж сурахад зарцуулдаг болох, мөн амьдралын бүхий л хүрээнд хүмүүст тухайн газрын нөхцөл, тусгай нөхцөл байдлын талаархи мэдлэг хэр үнэ цэнэтэй хөрөнгө байдаг талаар л бид санаж байх хэрэгтэй. Бүрэн гүйцэт ашигладаггүй машин техникийг мэддэг, ашигладаг байх эсвэл илүү сайн ашиглах боломжтой хэн нэгний чадварыг мэдэх, ашиглах, эсвэл нийлүүлэлт тасалдах үеэр татан авах боломжтой илүүдэл нөөцийн талаар мэдэх явдал бол нийгмийн хувьд илүү сайн хувилбар арга барилын талаархи мэдлэгийн адил нилээд хэрэгтэй зүйл юм. Мөн л хоосон эсвэл хагас ачаатай холхих уурын тэрэгний аялалыг ашиглаж амьжиргаагаа залгуулдаг ачаа илгээгч эсвэл бүх мэдлэг

7 *in the sense of knowledge of general rules*

нь түр зуурын боломжийн талаархи мэдлэг зөвхөн байдаг үндсэн хөрөнгө зуучлагч агент, эсвэл бараа таваарын тухайн газрын үнийн зөрүүнээс ашиг олдог зуучлагч наймаачин⁸ бүгдээрээ бусдад үл анзаарагдсан агшин зуур үргэлжлэх цаг хугацааны нөхцөл байдлын тусгай мэдлэгт тулгуурласан гайхалтай хэрэгтэй функцийг үйлдэж байдаг.

Өнөөдөр энэ төрлийн мэдлэгт өнөөдөр буруутгаж муушаасан байдлаар ерөнхийдөө ханддаг нь, мөн мэдлэгийн ийм төрлөөр болон техникийн мэдлэгээр илүү сайн зэвсэглэсэн бусдаас илүү ашиг олдог аливаа хүнийг бараг л увайгүй үйл хийсэн гэж боддог нь инээдэмтэй л бодит байдал юм. Хэдийгээр нийгэмд хамгийн сүүлийн үеийн ололт нээлтийг хэрэглэхийн адилаар энэ талын хамгийн сайн боломжийг ашиглах явдал нилээд чухал байдаг ч гэсэн харилцаа холбоо эсвэл тээврийн байгууламжийн талаархи илүү сайн мэдлэгийнхээ давуу талаас ашиг олохыг заримдаа бараг шударга бус хэрэг гэж үздэг. Энэхүү урьдаас тогтчихсон төсөөлөл ерөнхийдөө үйлдвэрлэлд хандахад байдалтай харьцуулахад арилжаа худалдаанд мэдэгдэхүйц нөлөөлжээ. Бүр өөрсдийгөө өнгөрсөн үеийнхээ бүдүүлэг материалист худал хуурмагт үл автдаг гэж үздэг эдийн засагчид иймэрхүү оновчтой мэдлэгтэй олж авах руу чиглэсэн үйл ажиллагааг анхаарч үзэхдээ мэдээжээр юмсынхаа бүдүүвч загвартаа иймэрхүү бүх мэдлэгийг “өгөгдсөн” гэж төсөөлж үздэг учраас л ийм алдаа үргэлж гаргадаг биз ээ. Одоо ийм бүх мэдлэг хүн бүрд хэрэгцээтэй үед нь бэлэн байх ёстой гэдэг санаа нийтлэг байгаа нь харагддаг бөгөөд эдийн засгийн одоо буй дэг журмын эсрэг хандсан иррационал байдл⁹ын буруутгал ийм мэдлэг тийм ч олдоцтой бус байна гэсэн бодит байдалд байнга л үндэслэж тулгуурласан байдаг. Энэ үзэл санаа иймэрхүү мэдлэгийг байж болохоор нь өргөн хэмжээнд хүртгээмжтэй болгох боломжтой арга барил бол бидний хариултыг нь эрж хайж буй яг тэр асуудал юм гэсэн бодит байдлыг үл тоодог билээ.

8 *arbitrageur-опос. арбитражер*

9 *reproach of irrationality*

IV

Хэрэв өнөөдөр цаг хугацаа болон газар орны тодорхой нөхцөл байдлын талаархи мэдлэгийн ач холбогдлыг бууруулах нь тийм таатай зүйл байгаа бол энэ байдал одоо ийм зүйлээр өөрчлөгдөх ёстой илүү бага ач холбогдолтой зүйлтэй нягт холбоотой байдаг. Үнэндээ “төлөвлөгч”-ийн (голдуу зөвхөн бүрхэг төдий) таамаглалаа гаргасан, сөргөлдөгч талаасаа үйлдвэрлэлийн төлөвлөгөөг мэдэгдэхүйцээр өөрчлөх явдлыг зайлшгүй зүйл болгодог өөрчлөлтийн ач холбогдол болон өөрчлөлт гарах давтамжийн хэмжээгээрээ л ондоо байдаг хэд хэдэн санаа бий. Мэдээжээр хэрэв эдийн засгийн нарийвчилсан төлөвлөгөөг урьдаас нилээд урт хугацаанд гаргах, дараагаар нь түүнээ эзийн засгийн чухал шийдвэр нэмж гаргахгүйгээр чанд мөрдөх боломжтой бол эдийн засгийн бүх үйл ажиллагааг захирч удирдах нарийн дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах ажил хамаагүй хор хохирол багатай байхсан.

Магадгүй эдийн засгийн асуудал үргэлж өөрчлөлтийн үр дагавар зөвхөн байдаг гэдгийг дурдах хэрэгтэй байж болох юм. Юмс өмнөх шигээ үргэлжилсээр, эсвэл дор хаяж бодож байсан шигээр нь үргэлжилсээр байвал шийдэл хэрэгтэй шинэ асуудал ургаж гарахгүй, шинэ төлөвлөгөө гаргах ч хэрэгцээ алга. Өөрчлөлт, эсвэл дор хаяж өдөр тутмын тохируулга орчин цагт чухал бус болсон гэсэн итгэл үнэмшил эдийн засгийн асуудал ч мөн чухал бус болсон гэж батлан өгүүлсэн зүйлийг дам харуулдаг. Өөрчлөлтийн ач холбогдлыг бууруулж буй энэхүү итгэл үнэмшлийг өмнөх шалтгааны улмаас эдийн засгийн эргэцүүллийн ач холбогдол технологийн мэдлэгийн өсч буй ач холбогдлоос болоод хоёрдугаар зэрэгтэй болсон гэж батлан өгүүлдэг тэр л хүмүүс бас баримталдаг.

Орчин үеийн үйлдвэрлэлийн тоног хэрэгсэлтэй үед эдийн засгийн шийдвэрийг шинэ үйлдвэр байгуулах эсвэл үйлдвэрлэлийн шинэ үйл явц нэвтрүүлэх зэрэг зөвхөн урт хугацааны интервалд л гаргах шаардлагатай болсон гэдэг нь үнэн болов уу? Нэгэнт үйлдвэр барьчихвал уг үйлдвэрийн шинж байдлаар тодорхойлогддог илүү сайн механикжсан эсвэл арай муу механикжсан үлдсэн бүх зүйл нь

цаг мөч бүр зогсолтгүй өөрчлөгдөж байдаг нөхцөл байдалд нийцэж тааран өөрчлөгдөхгүй гэдэг нь үнэн үү?

Ингэдэг гэж баталсан хариултанд итгэдэг нийлээд өргөн тархсан итгэл үнэмшил миний тодорхой болгож чадах хэмжээгээр бизнесмэний бодит туршлагаар батлагддаггүй. Ямар ч хамаагүй зэрэгтэй өрсөлдөөнтэй аж үйлдвэрлэлд зардлаа өсгөхгүй байх зорилготой байх нь хамаг тэнхээгээ баран байнга менежерүүд [хоорондоо] тэмцэлдэхийг шаарддаг — ийм аж үйлдвэр дангаараа [үр ашгийн] шалгуур байх боломжтой. Чадвар муутай менежер үр ашигт байдал суурьладаг ялгаатай байдлыг хэр хялбар багасгах чадах, мөн нэг ижил техникийн арга хэрэгслээр юм янз бүрийн өөр өртөг зардлаар үйлдвэрлэх боломжтой байх явдал бол эдийн засагчийн судалгаанд ижил тэнцүү танигдсан зүйл гэж харагддаггүй бизнесийн туршлагын ердийн л нэг зүйлс юм. Зардал мөнгөнд хязгаарлагдахгүйгээр ажлаа үргэлжлүүлэх боломж олж авах гэсэн үйлдвэрлэгчид, инженерүүдээс байнга сонстдог хүслийн чухам тэр л хүч хэмжээ эдгээр арга хэрэгсэл тэдний өдөр тутмын ажилд хэр хэмжээгээр хэрэг болж буйн яруу сайхан баталгаа^[10] билээ.

Эдийн засагчид яагаад нийт эдийн засгийн дүр зургийг бүрдүүлдэг байнгын жижиг өөрчлөлтийн талаар улам бүр л мартаж хандлагатай байдгийн нэг шалтгаан нарийн ширийн зүйлсийн хөдөлгөөн өөрчлөлтөөс илүүтэй маш их тогтвортой байдалтай гэж харагддаг статистик цогц бүрдэл^[11]д улам ихээр санаа тавих болсон явдал байж болох юм. Гэвч энэ цогц бүрдлийн харьцангуй тогтвортой байдлыг статистикч нар ингэж хийх хандлагатай гэж хааяа хааяа харагдагчлан “гом тооны хууль^[12]”-аар эсвэл санамсаргүй өөрчлөлтийн харилцан биесээ нөхөх явдлаар тооцоолж тайлбарлах боломжгүй. Бидний судлах элементийн тоо иймэрхүү санамсаргүй хүч тогтвортой байдал бүтээхэд хангалттай их байдаггүй. Өдөр бүр гардаг, тухайн өдрийн өмнө мэдэгдэхгүй байсан нөхцөл байдлын хүрээнд А хангаж чадахгүй болмогц Б

10 *eloquent testimony*

11 *statistical aggregates*

12 *law of large numbers*

нь түүнийг нь хангахаар орж ирдэг гэсэн шинэ зохицлоос бий болдог байнгын албадмал тохируулгаар бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний тасралтгүй үргэлжлэх урсгалыг хэвийн хэмжээнд байлгадаг. Бүр том, маш ихээр механикжсан үйлдвэр урьдаас таамаглах аргагүй зүсэн зүйлийн хэрэгцээт зүйлээ олж авах боломжтой хүрээлж буй орчин байгаа учраас л ажилласаар байна; эдгээр зүйлд дээвэртээ дээврийн хавтан, элдэв маягтдаа янз бүрийн бичиг хэргийн зүйл авах гээд өөрөө өөрийгөө хангаж чадахгүй, уг үйлдвэрийн ажиллагааг төлөвлөхөд зах зээл дээр шууд бэлэн байх шаардлагатай тоног төхөөрөмжийн бүх мянга нэгэн төрөл багтана.

Магадгүй энэ мөч би өөрийн анхаарал хандуулдаг мэдлэгийн төрөл бол шинж байдлаараа статистик мэдээлэл рүү оруулах боломжгүй, үүнээс улбаалаад аливаа төвийн засаг захиргаа статистик байдлаар дамжуулах боломжгүй тийм төрлийн мэдлэг юм гэсэн бодит байдлыг товчхон дурдах ёстой газар байж болох юм. Иймэрхүү төвийн засаг захиргаа хэрэглэх статистик мэдээлэл юмс үзэгдлийн хоорондохь бага жижиг ялгааг арилгасан, тухайлсан шийвэр гаргахад маш чухал байж болох байршил, чанар, бусад тодорхой шинжээрээ ялгардаг зүйлсийг нэг төрлийн эх сурвалж гэж хамтад нь нэгтгэх замаар чухамхүү нийлбэр болгосон байдлаар тэнд хүрч очих болно. Үүнээс үзвэл статистик мэдээлэлд тулгуурладаг төвлөрсөн төлөвлөлт шинж байдлаараа түүнд цаг хугацаа болон байршлын талаархи эдгээр нөхцөл байдлыг шууд тооцож үзэх боломжгүй, мөн төвийн төлөвлөгч эдгээр мэдээллээс хамаарч гарах тухайн шийдвэрийг “газар дээр нь байгаа хүн”-д үлдээх боломжтой энэ эсвэл тэр арга зам олох ёстой болно гэдэг нь харагддаг.

V

Хэрэв бид нийгмийн эдийн засгийн асуудал бол голчлон цаг хугацаа болон газар орны тодорхой нөхцөл байдлын өөрчлөлтөд түргэн шуурхай нийцэж зохицох явдал юм гэдэгт санал нийлбэл үүнээс улбаалаад эцсийн шийдвэрийг эдгээр нөхцөл байдлыг мэддэг, тийм нөхцөлд байдал нийцэхэд тохиромжтой өөрчлөлт, мөн түүнд нийцэхэд шууд бэлэн байгаа нөөц баялагийг бэлхэнээ мэддэг хүмүүст

үлдээх ёстой болох нь харагдана. Бид энэхүү асуудлыг юуны түрүүнд энэ бүх мэдлэгийг нэгтгэснийхээ дараа тушаал буулгадаг төвийн зөвлөлд харилцаж дамжуулах замаар шийдвэрлэх бололцоотой гэж бодох боломжгүй. Бид үүнийг төвлөрсөн бус байдлын ямар нэг хэлбэрээр л шийдвэрлэх ёстой. Гэвч энэхүү хариулт бидний асуудал бэрхшээлийн зөвхөн нэг л хэсэг билээ. Бид цаг хугацаа болон газар орны тодорхой нөхцөл байдлын тухай мэдлэгийг зохих ёсоор нь хэрэглэх явдлыг зөвхөн ингэж л баталгаажуулж чадах учраас төвлөрсөн бус байдал энд шаардлагатай. Гэвч “газар дээр нь байгаа хүн^[13]” түүнийг шууд хүрээлж буй бодит байдлын талаархи өөрийн хязгаарлагдмал боловч хувийн дотоод мэдлэгтээ зөвхөн үндэслэн шийдэх боломжгүй. Эдийн засгийн илүү том тогтолцооны өөрчлөлтийн ерөнхий хэвшинжид өөрийн шийдвэрээ нийцүүлэхэд нь шаардлагатай нэмэлт мэдээллийг түүнд дамжуулж өгөх асуудал байсаар л байна.

Түүнийг ингэж чадахад нь түүнд хэр их мэдлэг хэрэгтэй вэ? Мэдлэгийнх нь хүрээний цаана болдог үйл явцын аль нь түүний шийдвэрт тохиромжтой вэ, тэдгээр явцын талаар тэр хэр ихийг мэдэх шаардлагатай вэ?

Түүний гаргах ёстой шийдвэрт нөлөөлдөггүй, дэлхийн хаана нэгтэй болж буй ямар нэр зүйл олох нь хэцүү л байх болов уу. Гэвч тэрбээр эдгээр үйл явдлын талаар, мөн тэдгээрийн бүх нөлөөг мэдэх хэрэг байхгүй. Түүний хувьд тодорхой цаг мөчид тэр нэг хэмжээтэй шрүпээс илүүтэй өөр нэг хэмжээтэй шрүп илүү ихийг хүмүүс хүсч байгаа, яагаад нэхмэл торноос илүүтэй цаасан уут их байгаа, эсвэл яагаад чадварлаг ажилчид, эсвэл тодорхой машин багажийг тухайн цаг үед олж авахад хүндрэлтэй байгаа нь ер нь сонин биш. Түүний хувьд чухал байдаг бүх зүйл бол түүний мөн анхаарал хандуулдаг бусад зүйлтэй харьцуулахад эдгээр зүйлийг худалдаж авахад илүү их хэцүү эсвэл арай бага хэцүү болсон явдал, эсвэл түүний үйлдвэрлэдэг эсвэл хэрэглэдэг өөр юмс^[14]ыг [хэрэглэгчид] хэр

13 *man on the spot*

14 *alternative things*

илүү яаруу эсвэл хэр яаруудуу хүсч байгаа явдал юм. Энэ нь үргэлж түүний анхаарч буй тодорхой зүйлтэй харьцуулсан харьцангуй ач холбогдолын асуудал байдаг бөгөөд эдгээр зүйлийн харьцангуй ач холбогдлыг өөрчилдөг учир шалтгаан түүнийг хүрээлж буй орчнынь нь тэдгээр тогтсон тодорхой зүйлд нөлөөлөхөөс бусдаар түүний сонирхол үл татах ажээ.

Үүнтэй холбоотойгоор миний зөв “эдийн засгийн тооцоо”^[15] гэж нэрлэдэг зүйл бидэнд дор хаяж адил төстэй байдл^[16]аараа энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжтойг, үнэндээ үнийн тогтолцоогоор шийдвэрлэсээр байдгийг харж ойлгоход туслана. Бүр зарим, жижиг, өөрийгөө өөрөө болгодог, эдийн засгийн бүх өгөгдлийг эзэмшдэг цор ганц хянагч хүн нөөц баялаг байршуулах зарим нэг жижиг тохиргоог хийх мөч бүрдээ нөлөөнд нь автах боломжтой зорилго болон арга хэрэгслийн хоорондохь бүх харилцааг нэг бүрчлэн сайн мэддэггүй. Үнэн хэрэгтээ сонголтын цэвэр логик^[17]ийн асар их хувь нэмэр бол бүр иймэрхүү цор ганц ухаантан энэхүү асуудлыг зөвхөн эквивалент байдлын хэм хэмжээ^[18] (эсвэл “үнэ цэнэ,” эсвэл “орлуулах хязгаарын хэм хэмжээ”^[19])-г байгуулж, түүнээ байнга ашиглах замаар, ө.х., ховор нөөц баялагийн төрөл нэг бүрд, тухайн тогтсон тодорхой зүйлд агуулагддаг аливаа шинж чанараас үүсч гарах боломжгүй ч ерөнхий арга хэрэгсэл буюу эцсийн бүтцийн талаас түүний ач холбогдлыг илэрхийлж харуулдаг, эсвэл ач холбогдлыг нь хураангуйлж багцалсан тоон индекс оноож хамаатуулан шийдвэрлэх боломжтой гэдгийг итгэл төрөхүйцээр дэлгэж харуулсан явдал юм. Гарах аливаа жижиг өөрчлөлт бүрд тэрбээр бүх зохистой мэдээлэл хураангуйлагдаж багцлагдсан эдгээр тоо хэмжээгээр-гаргасан индекс (эсвэл ‘үнэ цэнэ’)^[20]-ийг л зөвхөн анхаарч үзэх болно; тоо хэмжээг нэг нэгээр нь тохируулж, тэрбээр бүхэл хэцүү бодлогын шийдийг *ab initio* буюу бүр эхнээс

15 “*economic calculus*” *proper*

16 *at least by analogy*

17 *pure logic-цэвэр утгазүй*

18 *rate of equivalence-эквивалент байдлын хэм хэмжээ*

19 *marginal rates of substitution*

20 *quantitative indices (or “values”)*

нь гаргахгүйгээр эсвэл аливаа үе шатанд нэг дор түүний бүх салбар салааг судлах хэрэгцээгүйгээр үйл хөдлөл²¹өө нийцтэйгээр дахин байршуулж эмхлэх боломжтой.

Ер нь бол субъектив үнэ цэнэ хувь хүмүүст төлөвлөгөөнийхөө нэг хэсгийг тааруулж нийлүүлэхэд тусладаг лугаа адилаар өөр өөр хүмүүсийн тус тусдаа үйлдлийг хооронд нь таацуулж нийлүүлэх байдлаар тохирох бодит байдлын талаархи мэдлэг олон хүмүүст сарниж тархсан байдаг тогтолцоонд үнэ ажиллах боломжтой. Үнийн тогтолцооны маш энгийн, улиг болсон жишээг түүний чухам юу гүйцэтгэдэгийг харж ойлгохын тулд түргэн зуур анзаарч харууштай. Дэлхийн хаа нэгтээ зарим нэг түүхий эдийг ашиглах, жишээлбэл цагаантугалга хэрэглэх шинэ бололцоо урган гарав эсвэл цагаантугалганы нийлүүлэлтийн нэг эх үүсгүүр алга болжээ гэж төсөөлцгөө. Бидний зорилгын хувьд энэ хоёр шалтгааны аль нь цагаантугалгыг илүү ховор болгосон эсэх нь ер хамаагүй, ерөөсөө хамаагүй байх нь маш чухал шүү. Цагаантугалганы хэрэглэгчдийн мэдэх хэрэгтэй бүх зүйл бол тэд нарын ашигладаг цагаантугалганы заримыг одоо үр өгөөжтэйгээр хаа нэгтэй ашиглаж буй, үүний үр дүнд тэд нар цагаантугалгаа хэмнэж үр ашигтай хэрэглэх ёстой гэсэн бодит байдал юм. Тэдний дийлэнх олонхид хаана хамгийн яаралтай хэрэглээ үүсч гарсан эсвэл ямар өөр хэрэгцээнд тааруулж тэд нийлүүлэлтээ хэмнэх хэрэгтэй болсон талаараа мэдэх хэрэгцээ байхгүй. Хэрэв тэдний зөвхөн зарим нь даруй шуурхай энэ шинэ эрэлтийг мэддэг тиймдээ ч нөөц баялагаа түүн рүү шилжүүлсэн бол, мөн хэрэв шинэ хоосон зайг ухаарч харсан хүмүүс эргээд энэ зайг өөр эх үүсгүүрээр дүүргэсээр байвал үр нөлөө нь эдийн засгийн нийт тогтолцоогоор хурдтай тархаж түгэх бөгөөд цагаантугалганы бүх хэрэглээнд зөвхөн нөлөөлөөд зогсохгүй бас түүнийг орлуулагч, орлуулагчийнх нь орлуулагчид, мөн цагаантугалга болон түүнийг орлуулагчид гэх мэтээр хийсэн бүх юмсын нийлүүлэлтэд ч нөлөөлдөг; энэ бүхэнгүйгээр энэхүү орлуулах явцыг бий болгоход гол хөдөлгөгч нь байсан хүмүүсийн асар олон нь ерөөсөө эдгээр өөрчлөлтийн анхдагч шалтгааныг мэдээгүй байсан байдаг. Энэ

21 *dispositions-байр байдал*

бүхэл зүйл түүний гишүүд нь нийт талбарыг бүхэлд нь судалж мэдчихдэг учраас биш харин тэр хувь гишүүдийн алсын харааны хязгаарлагдмал хувь талбарууд тохиромжтой мэдээлэл олон орчноор дамжин бүгдэд харилцан дамжихаар хоорондоо харилцан давхацсан байдаг учраас нэг зах зээл мэтээр үйл гаргадаг. Аливаа бараа таваард нэг л үнэ байдаг, эсвэл үүнээс илүүтэй тухайн газрын газар орны үнүүд нь тээвэр гм.-ийн зардлаар л тодорхойлогддог тэр байдлаар хоорондоо холбогддог гэсэн тэрхүү бодит байдал үнэндээ тухайн үйл явцад оролцдог бүх хүмүүсийн дунд сарниж тархсан байдаг бүх мэдээллийг мэддэг эзэмшдэг ганц ухаантан л гаргах боломжтой (энэ зөвхөн концепцын хувьд л боломжтой) шийдлийг бий болгоно.

VI

Бид үнийн системийг хэрэв бид жинхэнэ функцийг нь ухаж ойлгохыг хүсч байвал мэдээлэл харилцаж дамжуулах зориулалттай механизм гэж харах ёстой—энэ функц бол мэдээжээр үнэ илүү хатуу хөдөлшгүй болох тусам улам бүр төгс байхаа больдог функц юм. (Гэвч бүр үнэ нилээд хатуу хөшүүн болсон ч гэсэн үнийг өөрчлөх гэсэн хүч гэрээний өөр нөхцлийн өөрчлөлтөөр дамжин мэдэгдэхүйц хэмжээгээр ажилласаар байх болно.) Энэ тогтолцооны хамгийн чухал бодит зүйл болбоос уг тогтолцоог ажиллуулдаг мэдлэгийн эдийн засаг ажээ. Мөн энэ эдийн засгийн тогтолцоо бол зөв үйлдэл хийх боломжтой байхын тулд хувь оролцогч бүр хэрэндээ таарсан бага хэмжээгээр л мэдэх хэрэгтэй тийм мэдлэгийн эдийн засаг^[22] юм. Тэмдэг тэмдэглэгээний төрөл зүйлээр товчилсон тэр л хэлбэрээр [үнийн тогтолцоо] хамгийн чухал мэдээллийг л дамжуулдаг бөгөөд мөн үүнийг зөвхөн хэрэгтэй хүнд нь дамжуулдаг. Өөрчлөлтийг бүртгэх зориулалттай машин төхөөрөмжийн зүйл эсвэл үнийн хөдөлгөөнөөр илрэхээс өөр илүү зүйл хэзээ ч мэддэггүй өөрчлөлтөд өөрсдийн үйл ажиллагаагаа тохируулахын тулд хувь үйлдвэрлэгч нар инженер хүн хэдэн тоо бүхий хэмжүүрийн сумыг

22 *economy of knowledge*

харж суух боломжтой байдаг лугаа адилаар зөвхөн хэдхэн л сумны хөдөлгөөнийг ажиглах боломж олгодог харилцаа холбооны систем гэж үнийн тогтолцоог тайлбарлах нь ижил метафор зүйл^[23]ээ давж гарсан, эсвэл юу юунаас илүү тайлбар билээ.

Мэдээжээр эдгээр тохируулга магадгүй эдийн засагчил тэнцвэрт байдлынхаа шинжилгээ^[24]нд тэдгээрийг ойлгодог тэр утгаар хэзээ ч “төгс” бус байх болно. Гэвч энэ асуудалд бараг л хүн бүрийн зүгээс илүү сайн эсвэл арай муу төгс мэдлэгийн төсөөлөл таамаглалаар хандддаг бидний онолын/онолдох дадал зуршил маань биднийг үнийн механизмын жинхэнэ үнэн функцийг харж ойлгоход харалган болгож, түүний үр ашигт байдлыг нь үнэлж цэгнэхдээ илүүтэй алдаатай буруу стандарт ашиглах явдал руу хөтөлжээ гэж санаа зовдог. Тушаал гаргалгүйгээр, хэдийгээр [ховордсон] учир шалтгааныг нь хэдхэн хүн л мэдэж байсан ч, хэд сар явуулах мөрдлөгөөр ч хэн болохыг нь ялгаж таних боломжгүй байх байсан хэдэн арван мянган хүмүүсийг аливаа нэг түүхий эд ховордох тохиолдол энэхүү хэрэглэгдэхүүнийг хэрэглэхдээ эсвэл түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг илүү хайрлаж хэмнэдэг болгожээ гэдэг нь гайхалтай зүйл юм; ө.х., тэд нар зөв чиглэлд хөдөлж байна. Бүр байнга үргэлж өөрчлөгддөг дэлхий ертөнцөд ч бүгдээрээ тэдний ашгийнх нь хэмжээ үргэлж нэг ижил тогтмол байх эсвэл “жирийн” төвшинд хадгалагдаж байхаар хэл амаа төгс ололцож чадахгүй байсан ч энэ зүйл гайхамшиг байсаар байх болно.

Би “гайхамшиг” гэдэг үгийг уншигч нараа бид энэ механизм ажиллах явдлыг баталгаатай мэтээр үзэж өөрсдийгөө тайвшруулдаг тэр байдл^[25]аас нь гаргаж гайхшируулах гэж албаар хэрэглэлээ. Хэрэв үнийн энэ механизм/тогтолцоо хүмүний албадмал байдлаар гаргасан төлөвлөсөн бодлын үр дүн байсан бол, мөн хэрэв үнээр баримжаа авдаг хүмүүс тэдний шийдвэр өөрсдийнх нь ойрын зорилгоос ч давсан ач холбогдолтой гэдгийг ухаж ойлгодог байсан бол энэ механизмыг хүмүний ухааны аугаа ололт амжилтын нэг

23 *metaphor-Тайлбарлах*

24 *equilibrium analysis*

25 *complacency*

гэж зарлан тунхаглаж алдаршуулах байсан гэдэгт би бат итгэлтэй байдаг. Харамсалтай нь үнийн механизм хүмүний төлөвлөсөн бодлын үр дагавар биш бөгөөд түүгээр баримжаа авдаг хүмүүс яагаад хийж байгаа зүйлээ яагаад хийх ёстой болчихсоноо голдуу мэддэггүй нь бүр ч гайтай хэрэг. Гэвч бид өөрсдөө ухамсартайгаар шийдвэрлэж чадахгүй зүйлийг “ухамсартайгаар чиглүүлэх” ёстой гэж шаарддаг, мөн төлөвлөсөн бодолгүйгээр (бүр бид үүнийг ухаж ойлгохгүй байсан ч л) хувьсаж хөгждөг аливаа зүйлд итгэдэггүй хүн дараах зүйлийг санаж байх хэрэгтэй: Нөөц баялагийг хэрэглэх байдлыг аливаа нэг ухаантан хянах хүрээнээс цааш хэр хэмжээгээр хэрхэн тэлэх вэ гэдэг бол үүний хүндрэл бэрхшээл юм; үүнээс үүдээд ухамсартай хяналт тавих явдлыг хэрхэн хэрэгцээгүй болгох вэ, мөн тэдэнд юу хийхийг нь хэн нэгэн хэлж өгөхгүйгээр хувь хүмүүсээр хүсүүштэй зүйл хийлгэх явдлыг хэрхэн өдөөх вэ гэсэн явдал бэрхшээл болох болно.

Энд бидэнд тулгардаг асуудал аль ч талаараа зөвхөн эдийн засгийн ухааны өвөрмөц зүйл байдаггүй харин бараг бүгдээрээ жинхэнээсээ нийгмийн/социал үзэгдэлтэй, хэл яриатай, бидний соёлын өв уламжлалын ихэнхитэй холбоотойгоор ургаж гардаг бөгөөд эдгээр асуудал жинхэнээсээ бүх нийгмийн ухааны онолын гол асуудал болдог ажээ. Өөр шалтгаанаар ч гэсэн гэлээ Алфред Вайтхээд дараах зүйлийг хэлсэн байдаг: “Бүх хуулбарласан ном^[26]д байнга давтдаг, мөн бүх гарамгай хүмүүс итгэл яриагаа хийхдээ үргэлж гаргадаг илэрхий алдаатай улиг болсон зүйл^[27] бол бид юу хийж буй талаараа сэтгэж боддог зуршил бид өөрсөддөө суулгаж хөгжүүлэх ёстой гэж гэдэг явдал юм. Хэрэг явдал яг эсрэгээрээ байдаг. Иргэншил тухайлан бодохгүйгээр бид үйлдэх боломжтой чухал үйлдлийн тоог нэмэгдүүлэх замаар урагшилж хөгждөг.” Энэ байдал нийгмийн салбарт суурь ач холбогдолтой. Бид утга учрыг нь ойлгодоггүй, мөн хувь хувьдаа эзэмшдэггүй мэдлэгийн тусыг хүртэх боломж өөрсдөдөө олгодог тэр л томьёо, тэмдэг тэмдэглэгээ, дүрэм

26 *copy-books*

27 *truism- үнэн гэдэг нь илэрхий ч гэлээ шинэлэг зүйл эсвэл сонирхол татах зүйл агуулдаггүй хэлсэн зүйл ажээ*

журмыг байнга л ашиглаж хэвшжээ. Бид эдгээр дадал зуршил болон институтийг бидний хүрээлэлд амжилттай болох нь батлагдсан, мөн эргээд бидний байгуулсан иргэншлийн суурь болсон дадал зуршил болон институтээ чадавхижүүлж бүтээн үүсгэж хөгжүүлсэн билээ. Үнийн тогтолцоо бол хүн үүнийг өөрийг нь ухааж ойлгохгүйгээр таарч учирсныхаа дараа л (хэдий тэрбээр одоо ч үүнийгээ хамгийн сайнаар ашиглаж сурахдаа маш хол байгаа ч гэсэн) хэрэглэж сурсан эдгээр бүтцийн зөвхөн нэг л юм. Хөдөлмөрийн хуваариар зөвхөн зогсохгүй мөн ижил тэнцүү хуваагдсан мэдлэгт үндэслэн нөөц баялагийг хоорондоо хэлэлцэж тохиролцсон байдлаар ашиглах явдал энэ тогтолцоогоор дамжин боломжтой болжээ. Ийм байж болно гэсэн аливаа санал төсөөллийг элэглэх шоолох дуртай хүмүүс ихэвчлэн түүнийг [дэмжсэн] гаргалгаа нотолгоог ямар нэг гайхамшигаар орчин үеийн иргэншилд хамгийн сайн тохирсон тогтолцооны зүйл өөрөө-тогтох байдлаар ургаад гараад ирсэн гэж батлан өгүүлэн төөрөгдүүлэх байдлаар гажуулдаг. Үүний эсрэг зүйл болсон билээ: хүн [хөдөлмөрийн хуваарь]-ийг боломжтой болгосон арга барилтай санамсаргүй таарч учирсан учраас бидний иргэншил суурьладаг хөдөлмөрийн хуваарийг үүсгэж хөгжүүлэх боломжтой байсан. Үүнийг ингэж хийгээгүйсэн бол тэрбээр иргэншлийн ямар нэг өөр, бүхэлдээ ондоо төрлийг, термит шоргоолжны “төр улс” мэтгэй адилхан, эсвэл бүхэлдээ төсөөлөн бодох ч арга байхгүй төрлийг үүсгэж хөгжүүлэх боломжтой л байсаар байх байсан билээ. Бидний хэлж чадах бүх зүйл бол бүр түүн рүү хамгийн ширүүнээр дайрч давшилдаг ч хүнд ч эрхэм байх, оршин байгаа тогтолцооны тодорхой хэвшинжийн зүйлийг хадгалж үлдэх боломжтой, ялангуяа хувь хүн ямар хэмжээгээр өөрийн зорилгоо сонгох боломжтой байх, үүнээс улбаалаад үр дүнд нь өөрийн мэдлэг, ур чадвараа чөлөөтэй ашиглах боломжтой байхаар өөр хувилбар тогтолцоог хэн ч одоохондоо хараахан зохиомжилж гаргаж чадаагүй байгаа явдал юм.

VII

Нарийн нийлмэл нийгмийн хувьд аливаа рационал тооцоололд

үнийн тогтолцоо салшгүй зүйл байх эсэх талаархи маргаан одоо нэгэнт улстөрийн өөр өөр үзэл санаа баримталдаг талуудын хооронд ерөөсөө явагдахаа больсон нь олон талаараа азтай хэрэг. Биднийх шиг өргөн хэмжээнд тархсан хөдөлмөрийн хуваарьт суурьлаж тулгуурладаг нийгмийг үнийн тогтолцоогүйгээр хадгалах боломжгүй тухай номлол сургаалыг анх хорин таван жилийн өмнө фон Мизэс анх гарган хөгжүүлэхэд түүнийг нь их дуугаар элэглэн шоолж угтсан. Үүнийг хүлээн зөвшөөрөхөд одоо ч тулгарсаар буй зарим нэг хүндрэл өнөөдөр хэдийнээ улстөрийн голлох асуудал байхаа больсон бөгөөд энэ байдлаас хамаагүй илүү бүтээлч ухаалаг хэлэлцүүлгэ явуулах уур амьсгал бүрджээ. Бид Лев Троцкий “эдийн засгийн бүртгэл тооцоог зах зээлийн харилцаагүйгээр хийх талаар санахын ч хэрэггүй” гэж батлан өгүүлэхэд; Профессор Оскар Ланже Профессор Мизэст ирээдүйн Төлөвлөлтийн Төв Зөвлөлийн гантиг танхимд цээж барималыг нь тавина гэж амлахад; Профессор Абба Лернер Адам Смитийн талаар дахин олж мэдээд, үнийн тогтолцооны амин/чухал ашиг тус өөрийн ашиг сонирхлоо эрж хайж байхдаа нийт олны ашиг сонирхолд хэрэгтэй зүйлийг хийхэд хувь хүмүүсийг өдөөж сэдэлжүүлэх явдалд оршдог гэдгийг тодруулан хэлэхэд эдгээрийн ялгааг үнэндээ улстөрийн хэвшмэл үзэлд нэгэнтээ хамаатуулах боломжгүй болдог. Үлдэж буй санал үл нийлэх явдал цэвэр оюун ухааны зүйл болох нь, үүнээс илүүтэй ялангуяа аргазүйн ялгаа болох нь тод харагддаг.

Өөрийн бүтээл *Капитализм, Социализм, Ардчилалдаа* хэлсэн Жозеф Шүмпетерийн мэдэгдэлд миний бодож байсан аргазүйн ялгааны нэгнийх нь талаар ойлгомжтой илэрхийлжээ. Энэ номын зохиогч позитивизм^[28]ын тодорхой салбарын хүрээнд эдийн засгийн үзэгдэлд ханддаг эдийн засагчдын дунд хүндтэй байр эзлэдэг. Үүнээс болоод түүний хувьд эдгээр үзэгдэл нэг нэгтэйгээ бараг л хүмүний ухаан хөндлөнгөөс оролцох явдалгүйгээр гэж харагдахаар, шууд мөргөлдөж буй бараа таваарын бодит байдлаар өгөгдсөн тоо хэмжээ мэт байдалтай харагддаг ажээ. Энэхүү суурь нөхцөл

байдлын эсрэг би дараахь (намайг гайхшируулсан) мэдэгдл^[29]ийг л тайлбарлах боломжтой байна. Профессор Шүмпетер зах зээл байхгүй үед үйлдвэрлэлийн хэрэгсэлд зориулсан рационал тооцоолол хийх боломж тухайн онолчийн хувьд “хэрэглэгч нь хэрэглэгчдийн ашиг тусыг үнэлж цэгнэхдээ (“шаардахдаа”) *ipso facto* буюу үүнтэй холбоотой^[30]гоор эдгээр бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оролцдог үйлдвэрлэлийн хэрэгслийг мөн үнэлж цэгнэдэг гэсэн энгийн нөхцөл”^[31]-өөс үүсч гардаг гэж батлан өгүүлдэг.

Үгчилж ойлгосон ч энэхүү баталсан мэдэгдэл зүгээр л худал зүйл билээ. Хэрэглэгч иймэрхүү зүйл ер хийдэггүй. Профессор Шүмпетер “*ipso facto*” гэсэн нь үйлдвэрлэлийн хэрэгслийг үнэлэх гэдэг нь хэрэглэгчийн ашиг тусын үнэлгээ^[32]г дам хэлнэ эсвэл зайлшгүй үүнээс ургаж гардаг гэсэн үг байж болох юм. Гэвч энэ байдал мөн л худал ажээ. Төсөөлсөн таамаглал^[33] бол зөвхөн нэг хүнд, нэг л ухаантанд нэгэн зэрэг оршдог эргэцүүлэл бодлын хувьд

29 *pronouncement*

30 *ipso facto-by that very fact or act*

31 [1.]J. Schumpeter, *Capitalism, Socialism, and Democracy* (New York; Harper, 1942), p. 175. Профессор Шүмпетер бол миний итгэхээр Парето, Бэрон нар социалист тооцооллын асуудлыг “шийдвэрлэсэн” тухай домог ярианы зохиогч нь ажээ. Эд болон бусад олон хүний хийсэн зүйл бол зүгээр л нөөц баялагийг рационал байдлаар байршуулах явдлыг хангах ёстой нөхцөл байдлыг зарлан мэдэгдэх, мөн эдгээр нь өрсөлдөөнт зах зээлийн тэнцвэрт байдлын нөхцөлтэй үндсэндээ ижил зүйл болохыг цохон заах л явдал байв. Энэ бол эдгээр нөхцөлийг хангасан байдлаар нөөц баялагийг хэрхэн байршуулахыг бодит байдал мэддэг тухай асуудлаас бүхэлдээ ондоо ямар нэг зүйл юм. Парето өөрөө (Бэрон нь бараг түүний амнаас унасан болгоныг хуулдаг байсан) энэхүү бодит асуудлыг шийдсэн гэж мэдэгдээд зогсохгүй бас үнэндээ зах зээлийн тусламжгүйгээр энэ асуудлыг шийдэх боломжтой гэдгийг ил цагаан үгүйсгэж байсан. Түүний *Manuel d'économie pure* (2d ed., 1927), pp. 233–34 гэсэн бүтээлийг үзнэ үү. Тохирох богино өгүүлбэрийг “*Socialist Calculation: The Competitive ‘Solution,’*” in *Economica*, New Series, Vol. VIII, No. 26 (May, 1940), p. 125 дахь энэ нийтлэлийн эхэнд нь англи орчуулгад нь эшлэсэн билээ - ХАЕК-ийн эшлэл тайлбар, үүнийг орчуулагчийн эшлэсэн тайлбараас ялгах гэж томоор бичлээ.

32 *valuation of consumers' goods*

33 *Implication?*

утга учиртайгаар батлах хэлэх боломжтой логик харилцан хамаарал юм. Гэвч үйлдвэрлэлийн нөөц хэрэгсэл/арга хэрэгслийн үнэ цэнэ хэрэглэгчийн ашиг тусаас зөвхөн хамаардаггүй бас үйлдвэрлэлийн янз бүрийн нөөц хэрэгслийн нийлүүлэлтийн нөхцлөөс хамаардаг гэдэг нь илэрхий билээ. Эдгээр бүх бодит байдлыг нэгэн зэрэг мэдэж байсан ухаантанд л түүнд өгөгдсөн бодит байдлаас гарах зайлшгүй хариулт байх болно. Гэвч бодит бэрхшээл чухамхүү эдгээр бодит байдлыг хэзээ ч нэг ухаантан олж мэдсэн байдаггүй, мөн үүнээс болоод олон хүний дунд зайлбаргүй сарниж тарсан байх мэдлэгийг тухайн асуудлын шийдэлд хэрэглэх ёстой болдог учраас л урган гардаг.

Тийм учраас л хэрэв бид бүх бодит байдлыг (бид ажиглаж судалж буй эдийн засагч эдгээрийг мэддэг гэж хийсвэрээр төсөөлж буйчлан) нэг ухаантан мэдэж байсансан бол [тухайн асуудал]-ын шийдлийг тэрбээр ямар ч эргэлзээгүйгээр тодорхойлж чадна гэдгийг харуулж чадвал энэ асуудлыг шийдэх ямар ч арга зам байхгүй болохыг харуулна; үүний оронд бид нэг бүр нь мэдлэгийн зөвхөн хэсгийг нь мэддэг эзэмшдэг хүмүүсийн хоорондын харилцаагаар аливаа шийдэл хэрхэн гаргадгийг заавал харуулах ёстой. Эдийн засагчдын тайлбарладагчланаар бидэнд өгөгдсөн гэж үздэгтэй адилхан байдлаар бүх мэдлэг нэг ухаантанд өгөгдсөн гэж төсөөлөх нь уг асуудал бэрхшээл алга болчихсон гэж үзэж, бодит ертөнцөд чухал, бас мэдэгдэхүйц хэмжээтэй байдаг аливаа зүйлийг үл тоож буй хэрэг билээ.

Профессор Шүмпетер шиг зэрэг дэвтэй эдийн засагч “өгөгдөл” гэсэн хэллэгийн хоёрдмол утгаас санамсар болгоомжгүйгээс үүсдэг хавханд орсныг жирийн нэг алдаа гэж тайлбарлах хэцүүхэн л хэрэг байх болов уу. Энэ нь илүүтэй судалж буй юмс үзэгдлийнхээ амин чухал хэсгийг дадсан зуршлаараа үл тоомсорлодог бидний хандлагад сууриараа буруу ямар нэг зүйл байна гэдгийг харуулдаг: энэ гээгддэг зүйл бол хүний мэдлэгийн зайлах аргагүй төгс бус байдал, үүнээс үүдсэн мэдлэгийг байнга хоорондоо дамжуулж, олж авах үйл явцын хэрэгцээ юм. Хүмүүсийн мэдлэг тухайн нөхцөл байдлын үнэн зөв бодит байдалтай дүйцдэг гэсэн төсөөллөөс ерөөсөө үүсч гардаг,

тэнцэтгэлийн систем^[34] бүхий математик эдийн засгийн ухаан^[35]ы ихэнхид байдаг тэр л хандлагаас болж тайлбарлах ёстой гол ажил болох зүйлээ бид зүйтогтолтойгоор гээж орхино. Би тэнцвэрт байдлын шинжилгээгээр хэрэгтэй функц гүйцэтгэх боломжтой гэдгийг үгүйсгэмээргүй л байна. Гэвч энэ байдал бидний тэргүүний сэтгэгч нарыг уг байдлаар дүрсэлж тодорхойлдог нөхцөл байдал бодит асуудлын шийдэлд шууд тохиромжтой гэж итгэхэд хүргэвэл энэ зүйлээр ерөөсөө нийгмийн үйл явцыг судалдаггүй, мөн энэ нь тухайн гол асуудлын судалгаанд ашигтай урьдач бэлтгэл ажлаас өөр юу ч биш гэдгийг санах хэрэгтэй цаг аль хэдийнээ ирчихжээ гэсэн үг юм.

34 *simultaneous equations-орос. Система уравнений.* .

35 *mathematical economics-*